УХТЭ-ийн эрүүл мэндийн ажилтны коронавируст (COVID-19) халдварын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлсэн нь

Ц.Уянга[1], М.Орхон[1], Ш.Мягмарсүрэн[2], Н.Баярмаа[3], Х.Болор[3]

[1]Ариутгал Халдваргүйтгэлийн Тасаг, УХТЭ
[2]Эмнэлзүй Зохицуулалтын Алба, УХТЭ
[3]Хүний Нөөцийн Алба, УХТЭ
Цахим хаяг: ts.uyanga87@gmail.com Утас: 99828999

Түлхүүр үг:

Эрүүл мэндийн ажилтан
Коронавируст халдвар
Сургалт,
Мэдлэг, хандлага, дадал

Товч утга: 2019 оны 12 дугаар сарын сүүлчээс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хубей мужийн Ухань хотод шалтгаан тодорхойгүй уушгины хатгаа өвчний дэгдэлт бүртгэгдэж, 2020 оны 1 дүгээр сарын 7-нд шинэ төрлийн коронавирус (SARS-CoV-2)-ээр үүсгэгдсэн болохыг тогтоосон. 2020 оны 1 дүгээр сарын 31-ний байдлаар уг халдвар нь дэлхийн 20 улсыг хамарч эрчимтэй тархсан тул ДЭМБ-аас “Олон улсын шинж чанартай нийгмийн эрүүл мэндийн онц байдал” хэмээн зарлаж, 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр “Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахал бүртгэгдсэн” гэж үзлээ. Дэлхийн нийт хүн амын 2-3%-ыг эрүүл мэндийн ажилтан эзэлдэг. ДЭМБ-д мэдээлэгдсэн COVID-19 тохиолдлын 14 орчим хувь нь (зарим оронд энэ хувь хэмжээ 35% хүртэл) эрүүл мэндийн ажилтнууд байдаг. Мэдээллийн чанар хүртээмжээс шалтгаалан эрүүл мэндийн ажилтнууд ажлын байранд эсвэл олон нийтийн орчинд халдвар авсан эсэхийг тогтоох боломжгүй юм. COVID-19-ийн халдвар авсан эрүүл мэндийн ажилтнуудын 7000 орчим нь амь насаа алдсан байна. Иймээс Улсын хоёрдугаар төв эмнэлгийн нийт эрүүл мэндийн ажилтны Коронавируст халдвар (COVID-19)-ын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх замаар сургалтын хэрэгцээ тодорхойлох нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо.

Үндэслэл: 2019 оны 12 дугаар сарын сүүлчээс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хубей мужийн Ухань хотод шалтгаан тодорхойгүй уушгины хатгаа өвчний дэгдэлт бүртгэгдэж, 2020 оны 1 дүгээр сарын 7-нд шинэ төрлийн коронавирус (SARS-CoV-2)-ээр үүсгэгдсэн болохыг тогтоосон. 2020 оны 1 дүгээр сарын 31-ний байдлаар уг халдвар нь дэлхийн 20 улсыг хамарч эрчимтэй тархсан тул ДЭМБ-аас “Олон улсын шинж чанартай нийгмийн эрүүл мэндийн онц байдал” хэмээн зарлаж, 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр “Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахал бүртгэгдсэн” гэж үзлээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын мэргэжлийн зөвлөх багийн 2020 оны дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар уг халдварыг “COVID-19” хэмээн нэрлэж, олон улсын өвчний 10 дугаар ангиллаар U07.1 кодоор бүртгэж байна. ДЭМБ-ын мэдээллээр 2020 оны 10 дугаар сарын 27-ны байдлаар дэлхийн 216 улсад коронавируст халдвар (COVID-19)-ын 42,966,344 батлагдсан тохиолдол бүртгэгдэж, 1,152,604 хүн нас барсан байна. 2020 оны 10 дугаар сарын 27-ны байдлаар манай улсад уг өвчний зөөвөрлөгдөн ирсэн 340 батлагдсан тохиолдол бүртгэгдсэн. Иймд Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005)-ийн дагуу Коронавируст халдвар (COVID-19)-ын үед шуурхай хариу арга хэмжээ авах, тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна. Иймээс Улсын хоёрдугаар төв эмнэлгийн нийт эрүүл мэндийн ажилтны Коронавируст халдвар (COVID-19)-ын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх замаар сургалтын хэрэгцээ тодорхойлоход оршино.

Зорилго: УХТЭ-ийн эрүүл мэндийн ажилтны коронавируст (COVID-19) халдварын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх замаар сургалтын хэрэгцээ тодорхойлох

Зорилт:

1. Мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх
2. Сургалтын хэрэгцээ тодорхойлох

Хэрэглэгдэхүүн, арга аргачлал: Нэг агшингийн бичиглэл судалгааны аргаар судалгааг явуулсан. Мэдлэг, хандлага, дадал үнэлэх судалгааны 53 асуумж бүхий тест боловсруулж, асуумжийг 2020 оны 10 дугаар сарын 07-12-ныг хүртэл бүх тасгийн эрүүл мэндийн ажилтнуудаас (нийт 443) KAP судалгаа авч SSPS2016 программ дээр боловсруулалт хийж үр дүнг тооцсон.

1. Асуумжийн хэсэг:

1.1 COVID-19-ийн талаарх мэдлэг: Асуумжийн мэдлэг үнэлэх хэсэгт 26 асуулттай. Мэдлэгийн асуумж нь А болон Б хэсэгт хуваагдана.

А хэсэгт:

- Өвчний талаар (К1-К6),
- Өвчний шинж тэмдгийн талаар (К7 - К12),
- Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах талаар (К13-К18)

Дээрх асуултууд нь олон сонголттой хариулт хэлбэрээр, эсвэл үнэн, худал, эсвэл мэдэхгүй хэлбэртэй байв. Зөв хариултанд-3 оноо, буруу-1 оноо мэдэхгүй-2 оноо гэж үнэлэв. Мэдлэг үнэлэх А хэсгийн ерөнхий оноо 18-54 хооронд байна. Мэдлэг үнэлэх А асуултад 46 ба түүнээс доош оноо авсан бол мэдлэгийн түвшин бага, 47-50 хүртэлх оноо авсан бол дундаж, 50-аас дээш оноо авсан бол COVID-19-ийн халдварын үүсгэгч, шинж тэмдэг, халдвараас урьдчилан сэргийлэх, хянах талаар мэдлэгийн түвшин өндөр гэж үнэлсэн.

Б хэсэгт:

- Халдвар дамжих зам (К19-22),
- Халдварт өртөх эрсдэл (К23-К26)

Дээрх асуултууд нь үнэн, худал гэсэн хариултгай. Зөв хариулт-1 оноо, буруу хариулт-0 оноо гэж үнэлсэн. Мэдлэг үнэлэх Б хэсгийн ерөнхий оноо 0-8 хооронд байна. Мэдлэг үнэлэх Б асуултад 5-аас доош оноо авсан бол мэдлэгийн түвшин бага, 5-7 хүртэлх оноо авсан бол дундаж, 8 оноо авсан бол COVID-19-ийн халдвар дамжих зам болон эрсдэлтэй бүлгийн хүн амын талаар мэдлэгийн түвшин өндөр гэж үнэлсэн.

1.2 COVID-19-т хандах хандлага: Эрүүл мэндийн ажилтны COVID-19 халдварын талаар хандах хандлагыг 15 асуултаар үнэлсэн. (А1-А15, Хүснэгт 1). Оноог үнэн-3, худал-1, мэдэхгүй-2 гэж үнэлсэн. Нийт хандлагын оноо 15-45-ын хооронд хэлбэлзэж байв. Нийт 40-өөс доош бол бага, 40-43 бол дунд 43-аас дээш бол өндөр гэж тус тус ангилав.

1.3 COVID-19-ийн талаарх дадал: Эрүүл мэндийн ажилтны өвчлөлд хандах дадлын талаар 12 асуулт асуусан (Р1-Р15), (үнэн - 3, худал-1, мэдэхгүй -2). Нийт 29-өөс доош бол бага, 29-34 бол дунд, 34-аас дээш бол өндөр гэж тус тус ангилав. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Асуумжинд оноо өгч үнэлсэн байдал

Түвшин	Мэдлэг-А	Мэдлэг-Б	Хандлага	Дадал
Өндөр	50≤	8	43≤	34≤
Дунд	47-50	5-7	40-43	29-34
Бага	46≥	5≥	40≥	29≥

Үр дүн: УХТЭ-ийн нийт 513 эрүүл мэндийн ажилнуудаас 443 эрүүл мэндийн ажилтан судалгаанд хамрагдсан байна. Судалгаанд хамрагдалтын хувь 86.4% байна. Насны ангилалаар судалгаанд оролцогчдын 31.2% нь 21-30 насныхан байна. Мэргэжлээр нь ангилж үзэхэд эмч 105 (20.1%), сувилагч 158 (30.3%), үйлчлэгч 43 (8.2%), бусад эрүүл мэндийн ажилтан 135 (25.9%) хамрагдсан байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл (N=443)

Хариулт	Давтамж (*n*)	Эзлэх хувь (%)
Насны ангилал		
20-оос доош насны	7	1.3
21-30 насны	**163**	**31.2**
31-40 насны	122	23.4
41-50 насны	89	17
50-аас дээш насны	62	11.9
Хүйс		
Эрэгтэй	95	18.2
Эмэгтэй	**347**	**66.5**
Мэргэжил		
Эмч	105	20.1
Сувилагч	**158**	**30.3**
Үйлчлэгч	43	8.2
Бусад	135	25.9
Гэрлэлтийн байдал		
Гэрлэсэн	**309**	**59.2**
Гэрлээгүй	133	25.5
Ам бүлийн тоо		
1	28	5.4
2	48	9.2
3	119	22.8
4	**138**	**26.4**
5	68	13
6	26	5
7	6	1.1
8	2	0.4
10	1	0.2

Коронавируст (COVID-19) халдварын талаарх мэдлэг: Асуумжийн мэдлэг үнэлэх хэсэгт 26 асуулттай. Мэдлэгийн асуумжийг А,Б гэсэн 2 хэсэгт хуваасан. А хэсэгт өвчний талаар (К1-К6), өвчний шинж тэмдгийн талаар (К7-К12), өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах талаар (К13-К18) байна. Б хэсэгт өвчний дамжуулах зам (К19-22), эрсдэл өндөртэй бүлгүүдийн талаар (К23-К26) байна. Судалгааны үр дүн дундаж оноо А хэсэгт 47.1 (SD=3.1, rang=18-54) , Б хэсэгт 6.78 (SD=1.28, rang=0-8) гарсан нь мэдлэгийн түвшин “дунд” гэж үнэлэгдсэн. Мэдлэгийн асуумж болон Б хэсгүүдэд насны ангилал, хүйс, гэрлэлтийн байдал, ам бүлийн тоо зэргийн хамаарлыг судлахад хамаарал гараагүй боловч мэдлэг А хэсэг болон мэргэжил нь бага зэргийн хамааралтай гарсан. Мэргэжлийн байдлыг дотор нь эмнэлгийн болон эмнэлгийн бус мэргэжилтэн гэж 2 бүлэг хуваах үзэхэд эмнэлгийн мэргэжилтний мэдлэгийн түвшин ялгаатай гарсан.

Коронавируст (COVID-19) халдварын талаарх хандлага: Коронавируст (COVID-19) халдварт өвчинд хандах хандлагыг 15 асуултаар үнэлсэн. Судалгааны үр дүн дундаж оноо 39.92 (SD=4.359, rang=15-45) гарсан нь хандлагын байдал “дунд” гэж үнэлэгдсэн. Хандлагын байдлыг насны ангилал, хүйс, гэрлэлтийн

байдал, ам бүлийн тоотой хамааралтай эсэхийг судлахад хамаарал гараагүй боловч мэргэжил нь бага зэргийн хамааралтай байна.

Коронавируст (COVID-19) халдварын талаарх дадал: Эрүүл мэндийн ажилтны өвчлөлд хандах дадлыг 12 асуултаар үнэлсэн. Дундаж оноо 32.18 (SD=4.429, rang=12-36) гарсан ба дадал "дунд" гэж үнэлэгдсэн. Дадлын байдлыг нас, хүйс, мэргэжил, гэрлэлтийн байдал, ам бүлийн тоотой хамааруулж үзэхэд судлахад хамааралгүй байв.

Хүснэгт 3. Регрессийн холбоог хүн ам зүйн үзүүлэлт болон мэдлэг

Variable	Мэдлэг А		Мэдлэг Б		Хандлага		Дадал	
	CI 95%	P	CI 95%	P	CI 95%	P	CI 95%	P
Нас (жил)	-0.165 (-0.457-0.127)	0.266	0.015 (0.004-0.026)	0.512	0.138 (-0.271-0.547	0.507	-0.076 (-0.493-0.341)	0.720
Хүйс (эрэгтэй/эмэгтэй)	0.263 (-0.434-0.959)	0.459	0.132 (-0.154-0.417)	0.364	-0.142 (-1.119-0.835)	0.775	-0.373 (-1.369-0.624	0.463
Мэргэжил (эмнэлгийн/эмнэлгийн мэргэжилтэн)	-0.145 (-0.394-0.104	0.254	-0.044 (-0.146-0.058)	0.396	-0.282 (-0.631-0.68	0.114	-0.104 (-0.461-0.252)	0.565
Гэрлэлтийн байдал (гэрлэсэн/гэрлээгүй)	-0.179 (-0.871-0.513	0.612	-0.119 (-0.403-0.164)	0.408	-0.674 (-1.644-0.296)	0.173	-0.024 (-1.014-0.966)	0.962
Ам бүлийн тоо	-0.120 (-0.328-0.087)	0.255	0.001 (-0.084-0.086)	0.978	-0.183 (-0.474-0.108)	0.216	0.148 (-0.149-0.445)	0.327

Хэлцэмж: Угандад хийгдсэн судалгаагаар эрүүл мэндийн ажилтны мэдлэгийг түвшин ≥80%, хандлага ≥4,дадлага ≥2.4 байгаа нь бидний хийсэн судалгаанаас ялгаатай байна. Италид хийгдсэн судлагаагаар мэдлэг, хандлага, дадал үнэлсэн байдал нь 4.12 ± 0.749, 50.69 3.96, 35.97 ± 4.15 байна. Пакистанд хийгдсэн судалгаагаар мэдлэг, хандлага, дадал үнэлсэн байдал нь 17.31 ± 1.40 (range: 0 ~ 5), 8.54 ± 1.201 (range: 0 ~ 10), and 8.91 ± 1.431 (range: 0 ~ 10) байна. Мэргэжлийн байдлыг дотор нь эмнэлгийн болон эмнэлгийн бус мэргэжилтэн гэж 2 бүлэг хувааж үзэхэд эмнэлгийн мэргэжилтний мэдлэгийн түвшин ялгаатай гарсан нь УХТЭ дээр нийт 86 удаагийн 2694 эрүүл мэндийн ажилтныг хамруулсан сургалтттай холбоотой. Нийт сургалтын 20%-ийг дадлага буюу ажлын байранд дээрх сургалт эзэлж байна. Эмч сувилагч, тусгай мэргэжилтэнг 67 удаа, бусад мэргэжилтэнг 19 удаа тус тус сургалтанд хамруулсан байна. Үүнээс 2141(79.5%) нь эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн байна. Гэхдээ бидний хийгдсэн судлагаагаар мэдлэг, дадал "дунд" хандлага "бага" гэж үнэлэгдсэн байгаа нь ажлын байран дээрх сургалтын эзлэх хувь бага байгаатай холбоотой байх магадлалтай. Иймд дараа дараагийн сургалтыг танхмийн сургалтаас илүүтэйгээр ажлын байран дээрх дадлага сургалтыг түлхүү хийх нь, сургалтын арга хэлбэрийг өөрчлөх шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт: УХТЭ-ийн нийт 513 эрүүл мэндийн ажилнуудаас 443 эрүүл мэндийн ажилтан судалгаанд хамрагдсан байна. Судалгаанд хамрагдалтын хувь 86.4% байна. Насны ангиллаар судалгаанд оролцогчдын 31.2% нь 21-30 насныхан байна. Мэргэжлээр нь ангилж үзэхэд эмч 105 (20.1%), сувилагч 158 (30.3%), үйлчлэгч 43 (8.2%), бусад эрүүл мэндийн ажилтан 135 (25.9%) хамрагдсан байна. УХТЭ-ийн эрүүл мэндийн ажилтнуудын мэдлэг, хандлага, дадлын түвшин "дунд" гэж үнэлэгдсэн байна.

Ном зүй:

1. *World Health Organization (WHO). Naming the Coronavirus Disease. Available online:1*
2. *https://www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/technical-guidance/naming-the-coronavirus-disease-(covid-2019)-and-the-virus-that-causes-it (accessed on 15 August 2020).1.1*
3. *World Health Organization (WHO). Novel Coronavirus Situation Report-1. 2020. Available online: 1*
4. *https://www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/situation-reports (accessed on 15 August 2020).*
5. *WHO Director General. Media Briefing 11 March 2020 Covid-19 a Pandemic. Available online: https://www.who.int/dg/speeches/detail/who-director-general-s-opening-remarks-at-the-media-briefing-on-covid-19---11-march-2020 (accessed on 22 March 2020).*
6. *World Health Organization (WHO). Novel Coronavirus Situation Report-181. 2020. Available online:*
7. *https://www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/situation-reports (accessed on 19 July 2020).1*
8. *Wang, D.; Hu, B.; Hu, C.; Zhu, F.; Liu, X.; Zhang, J.; Wang, B.; Xiang, H.; Cheng, Z.; Xiong, Y.; et al. Clinical Characteristics of 138 Hospitalized Patients With 2019 Novel Coronavirus—Infected Pneumonia in Wuhan, China. JAMA 2020, 323, 1061. [CrossRef] [PubMed]3*
9. *World Health Organization (WHO). Report of the WHO-China Joint Mission on Coronavirus Disease2019 (COVID-19). Available online: https://www.who.int/publications-detail/report-of-the-who-china-joint-mission-on-coronavirus-disease-2019-(covid-19) (accessed on 15 August 2020).*
10. *Wu, Z.; McGoogan, J.M. Characteristics of and Important Lessons From the Coronavirus Disease 2019 (COVID-19) Outbreak*

in China. Summary of a Report of 72314 Cases From the Chinese Center for Disease Control and Prevention. JAMA 2020. [CrossRef] [PubMed]

11. *Zhan, M.; Qin, Y.; Xue, X.; Zhu, S. Death from Covid-19 of 23 Health Care Workers in China. N. Engl. J. Med.2020, 382, 2267–2268. [CrossRef]*
12. *Anelli, F.; Leoni, G.; Monaco, R.; Nume, C.; Rossi, R.C.; Marinoni, G.; Spata, G.; De Giorgi, D.; Peccarisi, L.; Miani, A.; et al. Italian doctors call for protecting healthcare workers and boosting community surveillance during covid-19 outbreak. BMJ 2020, 368, m1254. [CrossRef]12*
13. *Khan, S.; Khan, M.; Maqsood, K.; Hussain, T.; Huda, N.-U.; Zeeshan, M. Is Pakistan prepared for the COVID-19 epidemic? A questionnaire-based survey. J. Med. Virol. 2020, 92, 824–832. [CrossRef]13*
14. *Bureau of Statistics, Government of Pakistan Census 2017. Available online: http://www.pbs.gov.pk/content/14*
15. *provisional-summary-results-6th-population-and-housing-census-2017-0 (accessed on 19 March 2020).*
16. *World Health Organization (WHO). Risk Assessment and Management of Exposure of Health Care Workers in the Context of COVID-19. 2020. Available online: https://www.who.int/publications/m/item/risk-assessment-and-management-of-exposure-of-health-care-workers-in-the-context-of-covid-19-data-template (accessed on 18 October 2020).3*
17. *Asaad, A.M.; El-Sokkary, R.H.; Alzamanan, M.A.; El-Shafei, M. Knowledge and attitudes towards Middle East respiratory syndrome-coronavirus (MERS-CoV) among health care workers in south-western Saudi Arabia. East. Mediterr. Health J. 2019, 25. [CrossRef]17*
18. *Al-Hazmi, A.; Gosadi, I.; Somily, A.; Alsubaie, S.; Bin Saeed, A. Knowledge, attitude and practice of secondary schools and university students toward Middle East Respiratory Syndrome epidemic in Saudi Arabia: A cross-sectional study. Saudi J. Boil. Sci. 2016, 25, 572–577. [CrossRef]18*
19. *Abdel-Wahed, W.Y.; Hefzy, E.M.; Ahmed, M.I.; Hamed, N.S. Assessment of Knowledge, Attitudes, and Perception of Health Care Workers Regarding COVID-19, A Cross-Sectional Study from Egypt. J. Commun.Health 2020, 1–10. [CrossRef] Int. J. Environ. Res. Public Health 2020, 17, 6395 13 of 132*
20. *Papagiannis, D.; Malli, F.; Raptis, D.G.; Papathanasiou, I.V.; Fradelos, E.C.; Daniil, Z.; Rachiotis, G.; Gourgoulianis, K. Assessment of Knowledge, Attitudes, and Practices towards New Coronavirus (SARS-CoV-2) of Health Care Professionals in Greece before the Outbreak Period. Int. J. Environ. Res. Public Health 2020, 17, 4925. [CrossRef] [PubMed]2*
21. *Taghrir, M.H.; Borazjani, R.; Shiraly, R. COVID-19 and Iranian Medical Students; A Survey on Their Related-Knowledge, Preventive Behaviors and Risk Perception. Arch. Iran. Med. 2020, 23, 249–254. [CrossRef] [PubMed]3*
22. *Del Rio, C.; Malani, P.N. COVID-19—New Insights on a Rapidly Changing Epidemic. JAMA 2020, 323, 1339. [CrossRef] [PubMed]*
23. *Saqlain, M.; Munir, M.M.; Rehman, S.U.; Gulzar, A.; Naz, S.; Ahmed, Z.; Tahir, A.H.; Mashhood, M. Knowledge, attitude, practice and perceived barriers among healthcare workers regarding COVID-19: A cross-sectional survey from Pakistan. J. Hosp. Infect. 2020, 105, 419–423. [CrossRef]23*
24. *World Health Organization (WHO). COVID-19 and Food Safety: Guidance for Food Businesses; WHO: Geneva,*
25. *Switzerland, 2020.33. World Health Organization (WHO). Coronavirus Disease 2019, Advice for Public. Available online: https:*
26. *//www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/advice-for-public/myth-busters (accessed on 10 April 2020).*

Assessment of knowledge, attitudes, and practices of coronavirus (COVID-19) infection in health care workers

Ts.Uyanga[1], M.Orkhon[1], Sh.Myagmarsuren[2], N.Bayarmaa[3], Kh.Bolor[3]

[1]Department of Sterilization Disinfection, Second State Central Hospital
[2]Department of Clinical Statistics, Second State Central Hospital
[3]Department of Human Resources, Second State Central Hospital
Email: ts.uyanga87@gmail.com, Tel: 99828999

Abstract: An outbreak of unexplained pneumonia was reported in Wuhan, Hubei Province, People's Republic of China in late December 2019 and on January 7, 2020 and a new strain of coronavirus (SARS-CoV-2) was identified. As of January 31, 2020, the infection has spread rapidly to 20 countries around the world, and the World Health Organization has declared it an “international public health emergency”. It has been reported that healthcare workers make up 2-3% of the world's population. About 14 percent of the reported cases of COVID-19 in the World Health Organization (in some countries, up to 35%) are in health care workers. Due to the quality and availability of information, it is not possible to determine whether health workers are infected in the workplace or in the community. About 7,000 health workers infected with COVID-19 have died. Therefore, the basis for this study was to determine the need for training by assessing the knowledge, attitudes, and practices of all health workers at the Second State Central Hospital about coronavirus infection (COVID-19).

Key words: Second state central hospital, Healthcare workers, COVID-19, Knowledge, Attitude, Practice